



**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А106

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын "Төсвийн тухай" хуулийн дагуу 16 дугаар зүйлийн 16.1, 16.5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн төвийн зургаан дүүрэгт "11-100 кВт-ийн хүчин чадалтай" 1115 зуухны байгууламжийн эзэмшигч нарт Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны зөвлөмжийг дүүрэг хариуцсан гэрээт ажилтануудтай хамтран дээрх байгууламжид хүргэх "ажлын хэсэг"-ийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Зөвлөмж хүргэх 11-100 кВт-ийн хүчин чадалтай 1115 зуухны жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Тухайн ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, үр дүнг 2014 оны 6 дугаар сарын 16-ны дотор албаны даргад танилцуулахыг ажлын хэсэг /Г.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү ажлыг гүйцэтгэх явцад дүрмээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн албан хаагчдад, төрийн албаны хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс/ Ч.Цог /-түүрэг болгосугай.

ДАРГА



Ч.БАТСАЙХАН